

БЭЛГИЙН ХУЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ СЭТГЭЛ ЗҮЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

СЭТГЭЛ ЗҮЙЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

V



Энэхүү сэтгэл зүйн цогц үйлчилгээний хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк болон БНСУ-ын Цахим-Ази хөгжил түншлэлийн сангийн санхүүжилтээр Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй “Орон нутгийн оролцоонд тулгуурлан КОВИД-19 цар тахлын нөлөөг бууруулах нь” төслийн хүрээнд боловсруулав.



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЫН ЯАМ



From
the People of Japan

Хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “G9198/9221-МОН: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн сэтгэл зүйч, мэргэжилтнүүдэд зориулан хэвлэв.

БОЛОВСРУУЛСАН:

Д.ЦОГЗОЛМАА, Сэтгэл судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор

С.НАНДИН-ЭРДЭНЭ, Гүүд Нэйборс ОУТББ-ын Төсөл хөгжүүлэлтийн албаны мэргэжилтэн, сэтгэл зүйч

ХЯНАСАН:

А БҮРЭНЖАРГАЛ, Гүүд Нэйборс ОУТББ-ын Ахлах менежер

Г.НЯМБАЯР, Гүүд Нэйборс ОУТББ-ын Хөтөлбөр Зохицуулалтын Хэлтсийн менежер

Б.ЭРДЭНЭСУВД, Гүүд Нэйборс ОУТББ-ын Төсөл хөгжүүлэлтийн албаны ахлах мэргэжилтэн

ISBN: 978-9919-9011-3-4

© Энэхүү сэтгэл зүйн үйлчилгээний цогц хөтөлбөр нь Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын оюуны өмч тул зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн олшруулах, нийтлэх, нэвтрүүлэх, цахим системд оруулах болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

АГУУЛГА

I. ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

II. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

III. ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхээс өмнө анхаарах, бэлтгэх зүйлс

Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад анхаарах, бэлтгэх зүйлс

IV. ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТ, ЗААВАРЧИЛГАА

Хөтөлбөрт шаардагдах аргачлал, хэрэглэгдэхүүн

Нэг. Анхдагч холбоо тогтоох уулзалт

Хоёр. Сэтгэл зүйн үнэлгээ хийх уулзалт

Гурав. Сэтгэл хөдлөл тогтворжуулах уулзалт

Дөрөв. Асран хамгаалагч, эцэг эхтэй хийх уулзалт

V. ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ, БЭЛТГЭХ ЗҮЙЛС

Тулгарч болох бэрхшээл, даван туулах стратеги

VI. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Уулзалтын тэмдэглэлийн хуудас

Хавсралт 2. Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл

Хавсралт 3. Тайвшруулах амьсгалын дасгалын зааварчилгаа

Хавсралт 4. Сэтгэл зүйн үнэлгээний хуудас /Сэтгэл зүйчийн ажлын хуудас/

Хавсралт 5. Сэтгэл зүйн үнэлгээний хуудас /Үйлчлүүлэгчийн ажлын хуудас/

Хавсралт 6. Холбогдох эрхзүйн баримт бичгийн жагсаалт

Хавсралт 7. Хөтөлбөрийг дагалдах хэрэглэгдэхүүний танилцуулга

VII. НОМ ЗҮЙ

ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн 5 жилийн статистикаас харахад бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо жил ирэх тусам нэмэгдсэн байна. 2017 онд 187, 2018 онд 238, 2019 онд 253, 2020 онд 248, 2021 онд 278 бүртгэгджээ¹. ЦЕГ-ын Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс хийсэн судалгаанд хүүхэд хүчиндсэн гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь харуулбал, 72 хувь нь гэр, орон сууцанд, 6.2 хувь нь олон нийтийн газар, 1.9 хувь аж ахуйн нэгжид, үлдсэн хувь нь бусад газар үйлдэгджээ². Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын хувьд амиа хорлох эрсдэл өндөр байдаг болохыг уг судалгаанд дурдсан байна. Насны ангиллаар авч үзвэл, 9.1 хувь нь 0-7 хүртэлх насны, 35.1 хувь нь 8-13 насны, 55.6 хувь нь 14-17 насны хүүхэд хохирсон байна³.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо баримтыг “мөсөн уулын орой” хэсэгтэй зүйрлэдэг бөгөөд, энэ нь илрээгүй, бүртгэгдээгүй хэргүүд илүү олон байж болохыг илэрхийлж байна.

“Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэж хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ⁴” гэж тодорхойлсон байдаг. Бэлгийн хүчирхийлэлд өртөхөд хүргэж байгаа хэд хэдэн шалтгааныг нэрлэвэл,

- Хүүхэд болон гэр бүлийн гишүүд бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдийг тодорхой мэддэггүй. Жишээ нь: Зөвхөн бэлгийн харилцаанд оруулсан тохиолдлыг авч үздэг. Хүүхдийг оролдох, нүцгэн биеэ харуулахыг шаардах гэх мэт өөр бусад хэлбэрүүдийн талаар ойлголт багатай байдаг.
- Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж болохуйц нөхцөлд орсноо ойлгож өөрийгөө хамгаалах аргад суралцаагүй байдаг.
- Энэ талаар мэдээлэх нь өөрт нь болон гэр бүлийнхэнд нь аюул учруулна гэсэн айдсаас үүдэлтэй байдаг зэрэг нь бэлгийн хүчирхийлэлд өртсөөр байхад хүргэдэг түгээмэл шалтгаанууд юм.

Өсвөр насны хүүхдүүдийн хувьд бэлгийн хүчирхийлэлд өртсөн үед илрэх шинж тэмдэг нь тэдний бусадтай харилцах байдал, бэлгийн зан үйл ба өөрийн үнэлэмжид гарч буй өөрчлөлтөөр илэрнэ. Тухайлбал,

- Найз нөхөд болон аливаа үйл ажиллагаанд татагдах нь багасаж, сурах сонирхол хэт буурах
- Биед нь хүрэхэд айж цочих эсвэл бэлгийн шинжтэй үйлдлийг хэт сонирхох
- Насанд хүрэгчид болон өөрөөсөө илүү эрх мэдэлтэй хүмүүст дайсагнасан хандлагатай болох эсвэл дэргэдээ хэн нэгнийг байлгахыг эрмэлзэх
- Гэнэт дүрсхийн уурлах, гэрээсээ зугтаах, тэнэх
- Насандаа тохирохгүй жаахан хүүхэд шиг зан авир гарган харилцах
- Хувийн ариун цэвэр муутай болох, гаж болон хэтэрхий задгай байдлаар хувцаслах, олон давхар

1 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. ХОХИРСОН ХҮН, хүйс, насны ангилал, гэмт хэргийн төрлөөр

2 Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. “Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг”-ийн нөхцөл байдал дүн шинжилгээ хийсэн хэсэгчилсэн судалгаа, 2019

3 Мөн тэнд. “Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг”-ийн нөхцөл байдал дүн шинжилгээ хийсэн хэсэгчилсэн судалгаа, 2019

4 С.Энхтуяа, Хүүхэд хамгааллын үндэс, 2009. 46 хуудас


хувцас өмсөн зодуулсан шарх сорвио нуух

- ⦿ Онцын шалтгаангүйгээр бие нь байнга хямрах, хэвлий гэдэс орчмоор өвдөх, толгой өвдөх, дотор нь муухайрах
- ⦿ Бусдад үл итгэх болж, бусадтай хөгжилдөж чадахгүй болох
- ⦿ Мансууруулах бодис, архи, тамхи хэрэглэх
- ⦿ Өөрийнхөөрөө хэт зөрүүдлэх
- ⦿ Янз бүрийн хэлбэрээр бэлгийн замбараагүй харилцаанд орох шинжүүд илэрнэ.

Эдгээр шинжүүд илрэхээс гадна бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд сэтгэл зүйн гэмтэлд өртөх нь түгээмэл байдаг. Сэтгэл зүйн гэмтэл гэдэг нь тухайн хүний хувьд цаашдын харилцаа хандлага, мэдрэмж, хувь хүний онцлогт нөлөө үзүүлэхүйц хэмжээний таагүй үйл явдал тохиолдсон байхыг хэлнэ. Сэтгэцийн гэмтлийн нэг онцлог нь амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлж буй таагүй үйл явдал нь зөвхөн тухайн хүнд төдийгүй ойр дотны эсвэл хөндлөнгийн хэн нэгэнд тохиолдож байхыг биеэр үзэж мэдрэсэн үед авч болдог. Амьдралын үйл явдал нь хүн бүрд өөр өөр байдлаар тусах бөгөөд нэг удаа гүнзгий цочролд орох, эсвэл удаан хугацаанд үргэлжилсэн байх зэргээс хамааран ялгаатай хариу үйлдлээр илэрнэ.

Бид энэхүү хөтөлбөрийг бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдэд сэтгэл зүйн богино хугацааны, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд зориулан боловсруулсан бөгөөд зарим хууль эрх зүйн зохицуулалт, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудлууд үүсэх боломжтой. Иймд сэтгэл зүйн үнэлгээ хийгдсэний дараа бага болон дунд зэргийн эрсдэлтэй тохиолдолд энэхүү хөтөлбөрийн дагуу кейс нээн ажиллана. Харин өндөр эрсдэлтэй тохиолдолд нарийн мэргэжлийн байгууллагад холбон зуучилна.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИУЛАЛТ, ҮЕ ШАТ





УУЛЗАЛТ БУЮУ ҮЕ ШАТ ХООРОНДЫН ХУГАЦАА:

Хамгийн багадаа 1-3 хоног,
хамгийн уртдаа 7 хоног



АШИГЛАХ МАТЕРИАЛ:

Зөвлөгөөний хөтөлбөр, түүний хавсралт
болон дагалдах багц хэрэглэгдэхүүн



Жич: Кодыг мэргэжилтнүүд хоорондоо мэдээлэл солилцох зорилгоор хэрэглэж болно. Мөн кодыг Уулзалтын тэмдэглэлийн хуудаст /Хавсралт 1/ тэмдэглэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний онцлог нь сэтгэцийн гэмтэл авсны дараах богино болон урт хугацааны дараах үр дагаврыг багасгахад чиглэнэ.

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ХУВД ИЛЭРЧ БОЛЗОШГҮЙ ЗАН ҮЙЛ:



Бэлгийн харилцааны асуудалтай холбоотой зан үйл илрэх (бэлгийн харилцааны тухай сонирхох, судлах, ил задгай хувцаслах, бэлгийн харилцаанд орох хүсэлтэй болох гэх мэт)



Анхаарал төвлөрч
чадахгүй байх



Хичээлдээ
муудах



Гэрээсээ хол
байхыг хүсэх



Үе тэнгийнхэнтэйгээ
зохистой харьцаж
чадахгүй байх



Айдастай байх,
ялангуяа эрэгтэй хүн,
танихгүй хүнээс айх,
харанхуйгаас айх



Амиа хорлох бодол санаа
төрөх, оролдлого хийх
зэрэг байдал илэрч буй
эсэхийг насанд хүрэгчид
сайтар ажиглаж анхаарал
хандуулах хэрэгтэй.

Хүүхдийг бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон талаар мэргэжилтэн мэдсэн бол түүнийг нуун далдлах ёсгүй бөгөөд анхдагч холбоог зөв тогтоох, үнэлгээ хийх, хүүхдийн сэтгэл хөдлөлийг тогтворжуулах, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх, холбогдох мэргэжлийн байгууллагуудад зуучлах нь зүйтэй.

<p>БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ</p>	<p>Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь хэн нэгэн этгээд хүүхдийн бэлгийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан эсвэл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйг хэлнэ.⁵</p>
<p>БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛ</p>	<ul style="list-style-type: none"> • Сэтгэл зүйн боловсрол олгох, мэдээллээр хангах, урьдчилан сэргийлэх • Сэтгэл зүйн үнэлгээ хийх • Сэтгэл зүйн зөвлөгөө • Сэтгэл засал
<p>АНХДАГЧ ХОЛБОО ТОГТООХ</p>	<p>Бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар мэдээллийг хүүхэд сэтгэл зүйчид анх дуулгах болон энэ мэдээллийг мэргэжилтэн бусад хүмүүсээс авсны дараа анхны уулзалтыг анхдагч холбоо тогтоох гэж ойлгоно. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй анхдагч холбоог зөв тогтоох нь мэргэжлийн тусламж үр дүнтэй явагдах нөхцөлийг бүрдүүлдэг.</p>
<p>НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ</p>	<p>Нөхцөл байдлын үнэлгээ гэж үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалтай холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар судлах аргыг хэлнэ. 6</p>
<p>АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ</p>	<p>Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүчирхийлэгчид хууль ёсны шаардлага, анхааруулга өгөх, хүчирхийллийн аюулын зэргийг тодорхойлох, хүчирхийлэгчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах үйл ажиллагааг хэлнэ. 7</p>
<p>ХОЛБОН ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ</p>	<p>Холбон зуучлах үйлчилгээ гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд хүчирхийллийн улмаас учирсан, учирч болзошгүй хор уршиг, үр дагаврыг арилгах зорилгоор шаардлагатай хамгаалалт, үйлчилгээ, туслалцаа үзүүлэх, холбогдох мэргэжилтэн байгууллагатай холбож өгөх, үйлчилгээний чанар үр дүнд хяналт тавих, үнэлэх цогц үйл явцыг хэлнэ. 8</p>

5 С.Энхтуяа, Хүүхэд хамгааллын үндэс, 2009, 46-р тал

6 Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 7 сарын 4-ний өдрийн А/1201, А/178 тоот тушаал, Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам

7 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаал Аюулын зэргийн үнэлгээ хийх журам

8 Монгол улсын Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2017 оны 4 сарын 20-ны өдрийн А/73 тушаал “Холбон зуучлах үйлчилгээний журам

СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛ

Тухайн хүний хувьд цаашдын харилцаа хандлага, мэдрэмж, хувь хүний онцлогт нөлөө үзүүлэхүйц хэмжээний таагүй үйл явдал тохиолдсон байхыг хэлнэ. Сэтгэцийн гэмтлийн нэг онцлог нь амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлж буй таагүй үйл явдал нь зөвхөн тухайн хүнд төдийгүй тухайн хүний ойр дотны эсвэл хөндлөнгийн хэн нэгэнд тохиолдож байхыг биеэр үзэж мэдэрсэн үед авч болдог. Амьдралын үйл явдал нь хүн бүрд өөр өөр байдлаар тусах бөгөөд нэг удаа гүнзгий цочролд орох, эсвэл удаан хугацаанд үргэлжилсэн байх зэргээс хамааран ялгаатай хариу үйлдлээр илэрнэ.

**ОЙРЫН ҮЕД ИЛРЭХ ҮР
ДАГАВАР**

Сэтгэл хөдлөл /сэтгэлээр унах, түгших/, танин мэдэхүйн /салдаггүй бодол санаа үүсэх/, төрх үйлийн, вегетатив /нойр, хоолны дуршил өөрчлөгдөх/, сэтгэцийн гэмтэл үүсэх гэх мэт

**ХОЖУУ ИЛРЭХ ҮР
ДАГАВАР**

Бэлгийн зан үйл өөрчлөгдөх, тогтвортой харилцаа үүсгэж чадахгүй байх, эсрэг хүйсийн хүнийг үзэн ядах, айх, хүүхэд хүмүүжүүлэхэд бэрхшээл үүсэх, сэтгэцийн өөрчлөлт, тулгамдсан асуудал, нийгмийн эсрэг үйлдэл хийх гэх мэт

ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТ, ЗААВАРЧИЛГАА

ХӨТӨЛБӨРТ ШААРДАГДАХ АРГАЧЛАЛ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1 ЭВЕРЛИЙН АМЬСГАЛЫН ДАСГАЛ

Энэхүү дасгал нь богино хугацаанд тайвшруулах, булчин суллах, айдас, сэтгэл түгшилтийг багасгахад чиглэсэн. Дасгалыг хэвтээ, суугаа, босоо аль ч байдлаар хийх боломжтой бөгөөд үргэлжлэх нийт хугацаа 3-5 минут байна.

2 БУЛЧИН СУЛЛАХ ДАСГАЛ

Стрессийн үед биед үзүүлэх хариу үйлдлийг бууруулах, тэр дундаа булчингийн өөрчлөлтийг ажиглаж, түүнийг удирдахад чиглэсэн дасгал. Ингэснээр сэтгэл зүйн байдлаас шалтгаалж биед үзүүлсэн нөлөөллийг зохицуулах байдлаар сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах ач холбогдолтой.

3 БАНХАР КАРТ, ЭСВЭЛ СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН БУСАД КАРТ

Хүүхэд өөрийн мэдрэмжийг ярих сонирхолгүй, эсвэл илэрхийлж чадахгүй байгаа үед богино хугацаанд сэтгэл санаа, бие махбодын талаар мэдээлэл авах ач холбогдолтой.

4 ЛЮШЕРИЙН ӨНГӨ ЯЛГАХ ТЕСТ (ГАР ӨНГӨ, ПРОГРАММ)

Уг тест нь тухайн үеийн сэтгэл зүйн байдал, стресс, түүний шалтгаан, ядралт, идэвх зэргийг судлан илрүүлдэг. 8 үндсэн өнгөнүүдээс өөрт таалагдаж буй дарааллаар сонголт хийлгэж, үр дүнг компьютерийн програмд боловсруулдаг.

5 PTSD ТҮРГЭВЧИЛСЭН АСУУЛГА

Сэтгэцийн гэмтэл авсан эсэхийг үнэлэх нийт 7 асуулгатай. Сүүлийн нэг сарын байдлыг бодож, тийм эсвэл үгүй гэсэн хариулт авна.

6 CRIES АСУУЛГА

Сэтгэл зүйн гэмтэл хүүхдэд хэр хүчтэй нөлөөлж буйг илрүүлэхэд чиглэсэн нийт 13 асуулттай асуулга.

7 НИЙЛЭМЖИЙН АРГА

Зорилго: Энэхүү арга нь шинжлүүлэгчид тухайн мөчид ямар нийлэмж зонхилон үүсэж байгааг илрүүлдэг. Хэрэглэхэд хялбар, богино хугацаанд шинжлүүлэгчийн талаар нарийн мэдээлэл авах боломжтой тусгалын арга юм. Судлаачаас ур чадвар шаардана. Санаандаа орсон үгнүүдийг аль болох бодолгүй, түргэн нэрлэх эсвэл бичих даалгавар өгнө.

ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭЭС ӨМНӨ АНХААРАХ ЗҮЙЛС, БЭЛТГЭЛ АЖИЛ

Зөвлөгөөний өрөө болон орчныг бэлтгэх:

- “ Уулзалт эхлэхээс өмнө зөвлөгөөний өрөөний агаарыг сэлгэх, байгалийн гэрэл туссан байхыг бодож гэрэлтүүлэг гаргах. Хэрэв гаднаас байгалийн гэрэл тусах боломжгүй бол ширээний гэрэл зэргийг асааж болно. Өрөөнд агаар, гэрэл оруулах нь чөлөөтэй, тайван мэдрэмжийг үйлчлүүлэгчид өгөхөд тусална.
- “ Зөвлөгөөний өрөөний сандал нь үйлчлүүлэгчид тухтай мэдрэмж төрүүлэхүйц зөөлөн байвал сайн. Мөн үйлчлүүлэгч өөрийн биед тухтай байдлаар ашиглах боломжтой дэрнүүдийг бэлтгэнэ. Сандлыг байрлуулахдаа 1.5 метр орчим зайтайгаар сэтгэл зүйч үйлчлүүлэгч суухаар, сэтгэл зүйчийн суух сандал хаалганд талдаа байвал зохимжтой. Мөн зөвлөгөөний өрөөний ширээг 2 сандлын голд байрлуулна. Гэхдээ сэтгэл зүйч ширээн дээр цаас тавьж тэмдэглэл хийхээс зайлсхийгээрэй. Ширээн дээр бичихийн оронд гар самбар ашиглах нь зохимжтой.
- “ Зөвлөгөөний өрөөнд хурц өнцөгтэй, урт хатуу навчтай, улаан өнгөтэй цэцэг байхаас зайлсхийгээрэй. Мөн зөвлөгөөний эхлэл үед үйлчлүүлэгчээс өрөөнд байгаа зүйлс тухгүй мэдрэмж төрүүлж байгаа эсэхийг тодруулж асуугаарай.
- “ Бусад үйлчлүүлэгч, мэргэжилтнүүд зөвлөгөөний явцад саад болох, сарниулахаас сэргийлж зөвлөгөөтэй байгааг сануулах, илэрхийлэх бичиг өлгөж болно.
- “ Ширээн дээр хуурай салфетка байрлуулах.

Хөтөлбөрийн дагуу хэрэглэгдэхүүн болон бусад бэлтгэл:

- “ Гар самбарыг, бичгийн цаас, бал, уулзалтын тэмдэглэлийн хуудасны хамт бэлтгэх. /Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг “Хавсралт 1”-т оруулав./
- “ Үйлчлүүлэгч ярилцахыг хүсэхгүй байх тохиолдолд өөр ашиглаж болох арга техникийг бодолцож бэлтгэсэн байх.
- “ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ уулзалт бүрийг кодолж, үе шатыг дарааллын дагуу хэрэгжүүлэхэд анхаарах.
- “ Уулзалт бүрийн дагуу тэмдэглэлийг хөтлөх.

Бэлгийн хүчирхийллийн даван туулагчид үйлчилгээ үзүүлэхэд анхаарах:

Сэтгэл зүйч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч, түүний дотор бэлгийн хүчирхийлэл ба ураг төрлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний гэр бүлд зөвлөгөө өгөхдөө нийгэм - сэтгэл зүйн зөвлөгөөний суурь зарчмуудыг баримтлахын сацуу бэлгийн хүчирхийллийн онцлогтой холбоотой өвөрмөц зарчмуудыг мөн баримтлах шаардлагатай.

Нийгэм - сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд баримтлах суурь зарчмууд:

- “ Хүний эрхэд суурилсан хандлагыг мөрдөх: Энэ нь сэтгэл зүйч бол хүний эрхийг, түүний дотор хүүхдийн эрхийг хэрэгжүүлэгч субъект, үйлчлүүлэгч бол эрх эзэмшигч гэдэг зарчмыг баримталж ажиллахыг хэлнэ. Энэ үүднээс сэтгэл зүйч нь үйлчлүүлэгчийнхээ эрхийг хүндэтгэх, хамгаалах, хөхүүлэн дэмжих үүрэг хүлээнэ.

- “ Нууцлалыг хадгалах: Болсон явдлын талаар хэнд хэлэхийг хүсэж байгаагаа тодорхойлоход нь та хохирогчид туслалцаа үзүүлэн яаж үүнийгээ мэдэгдэх вэ гэдэгт нь тусална. Мөн та өөрийнхөө нууцлалын хүрээг хохирогчид ойлгуулах хэрэгтэй. Хэрэв та болсон явдлын тухай хохирогч өөрийн гэр бүлийнхэн болон мэргэжлийн бусад хүмүүст мэдэгдэх шаардлагатай бол энэ тухай эхлээд үйлчлүүлэгчдээ хэлэх хэрэгтэй. Зарим хохирогч таны туслалцааг талархан хүлээн авдаг.
- “ Үйлчлүүлэгчийн хувийн орон зайг хангах: Үйлчлүүлэгчтэй заавал зөвлөгөө өгөх тусгай өрөөнд ярилцана. Ялангуяа бэлгийн халдлагын талаар бусад хүний дэргэд ярихыг албадаж болохгүй. Бэлгийн харилцаатай холбоотой зөвлөгөөг ая тухтай, үйлчлүүлэгчийн хувийн орон зайг хангасан орчинд өгөх нь илүү тохиромжтой.
- “ Үйлчлүүлэгч туслалцаа, дэмжлэг хүсэж хандахад нь нөлөөлөх: Ихэнх хохирогчид эрүүл мэндийн, нийгмийн гэх мэт дэмжлэг туслалцаа чухал байдаг. Иймд тусламж хайх, мэргэжлийн байгууллагад хандахад нь тэдэнд нөлөөлж, зуучилж, дэмжих хэрэгтэй. Гэхдээ тухайн хүн өөрөө хүсэхгүй байхад туслалцаа ав гэж тулган шаардаж болохгүй.
- “ Шаардлагатай мэдээллийг зөв зохистой аргаар өгөх: Үйлчлүүлэгчийн тавьсан ямар ч асуултад хариулах хэрэгтэй. Цаашид юу болох тухай товчхон тайлбарлах нь чухал. Хохирогчид өөрийнхөө нэр, утасны дугаараа яамагт мэдээлэх нь зүйтэй.

Бэлгийн хүчирхийллийн онцлогтой холбоотой өвөрмөц зарчмууд:

- “ Та түүнд итгэж байна гэдгээ ойлгуулах: Ихэнх хохирогч өөрт нь итгэхгүй байх гэж бодсоноос болоод болгоомжтой байж өөрийгөө хамгаалах байдалд ордог. Хэрэв та түүнд зүгээр л итгэж байгаагаа хэлэх юм бол хохирогч биеэ барихаа больж, юу болсноо танд ярих болно. Үнэн зөв мэдүүлж байгаа эсэхийг дүгнэх, нотлох нь сэтгэл зүйчийн үүрэг биш болохыг анхаарах.
- “ Үйлчлүүлэгчийнхээ мэдрэмж, сэтгэл рүү хандах: Хохирогчид тайвшрах боломж өгч сэтгэл санааг нь засаад, юу санаж байгааг нь өөрөөр нь сэтгэлээ онгойтол яриулахыг оролдох хэрэгтэй. Ийм аргаар та хамгийн үнэн зөв, дэлгэрэнгүй мэдээлэл авах болно. Эхлээд шалихгүй зүйл мэт санагдах жижиг зүйл ч мэдээллийн хамгийн чухал хэсэг байж болдог.
- “ Аюулгүй байдлаа хангахад нь хохирогчид туслах: Хохирогч хүчин болон бэлгийн халдлагын тухай анх ярьж байхдаа айдас болон өөртөө итгэлгүй байдлыг мэдэрдэг. Тэр ганцаараа үлдэхээсээ айж болох бөгөөд бүх юм ёс журмын дагуу бүртгэгдсэний дараа аюулгүй газар очихыг түүнд зөвлөнө. Зарим хохирогчид гэртээ эргэн очиж чаддаггүй. Ийм тохиолдолд сэтгэл зүйч аюулгүй газар очиход нь хохирогчид туслах хэрэгтэй.
- “ Хохирогчийн сэтгэлийн шархыг дахин давтан хөндөхөөс зайлсхийх: Хохирогчоор болсон явдлын талаар олон дахин яриулж сэтгэлийн шархыг нь хөндөхгүй байх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Гэвч бодит байдал дээр хуулийн байгууллагаар асуудал шийдвэрлэгдэж дуустал байнга сөхөгддөг учир сэтгэл зүйчид зарим талаараа хүндрэл учруулдаг. Иймээс үйлчлүүлэгчдээ тухайн асуудлаа хэрхэн даван туулахад туслах шаардлагатай бөгөөд, ямар хугацаа зарцуулагдах, тухайн үе шатуудад ямар туслалцаа, дэмжлэг үзүүлэх талаар мэдлэгтэй байвал энэ нь хүндрэлийг бууруулах боломжтой байдаг.
- “ Болсон явдалд буруугүй гэдгийг хэлж өгөх: Зарим тохиолдолд хохирогчийг шууд буруутгах хандлага гардаг. Мөн хохирогч өөрийгөө хамгаалж чадаагүй гэж буруутгагдахаас эмээн хуулийн байгууллагад хандахгүй тохиолдлууд олон гардаг. Иймд гэмт хэргийн хариуцлагыг хэрэг үйлдэгч үүрэх ёстой ба болсон явдалд хохирогч буруугүй гэдгийг ямар ч хоёрдмол санаагүйгээр ойлгуулах хэрэгтэй.
- “ Өөрийн бодлоо бүү илэрхийл: Сэтгэл зүйч хохирогчийг буруутгах, урьдчилсан дүгнэлт хийх хандлага гаргахгүй байх. “Яагаад” гэсэн үгээр эхэлсэн асуулж тавихгүй байх. Жишээ нь: Яагаад та хүргээд өгье гэсэн урилгыг хүлээж авсан юм бэ? Яагаад та тэднийд очсон юм бэ? эсвэл та яагаад эсэргүүцэл үзүүлээгүй юм бэ? гэх мэт.

Сэтгэл зүйчийн хувийн бэлтгэл болон хувцаслалт

“ Уулзалтын өмнө кейстэй танилцаж, мэдээлэл авсан байх

“ Сэтгэл зүйч уулзалтын өмнө өөрийн сэтгэл зүй (үйлчлүүлэгчийн асуудалтай адил өөрт тулгамдсан асуудлаа шийдвэрлэсэн, эсвэл ийм асуудалтай тулгарч байгаагүй байх, тухайн үед тайван элдэв айдас түгшүүргүй, уулзалтын өмнө эцэг эх, асран хамгаалагч эсвэл үйлчилгээнд зуучилсан мэргэжилтнээс хүүхдийн нөхцөл байдлын тухай мэдээлэл авсан байх) хувцаслалт (ажил хэрэгч, хэт задгай буюу цээж, хөлийн хуруу, шагай ил гараагүй байх, гэрэлтээгүй, богино хувцаслаагүй байх гэх мэт), нүүр будалт, гоёл (өдөр тутмын буюу хэт тод, гүн будалт хийхгүй байх, гоёл нь хэт чамин, гялгар, үнэтэй биш байх) зэргийг шалгаж зохих хэмжээнд байлгахад анхаарах

СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЯВЦАД АНХААРАХ, БЭЛТГЭХ ЗҮЙЛС

Сэтгэл зүйн арга, аргачлалыг ашиглах явцад анхаарах, бэлтгэх:

Тайвшруулах дасгал, аргуудыг ашиглах явцад доорх зүйлсийг анхаарах:

- Үйлчлүүлэгчид санал болгож буй тайвшруулах аргыг ажиллуулахаас өмнө тухайн дасгалын ач холбогдол, үзүүлэх эерэг нөлөө, ямар учраас энэ дасгалыг санал болгож буй зэргийг үйлчлүүлэгчийн нас, сэтгэл зүйн онцлогт тохиромжтой байдлаар тайлбарлах.
- Тайвшруулах дасгалын явцад үйлчлүүлэгчийн бие махбод, сэтгэл зүйг бэлтгэнэ.

Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйг бэлтгэх. Үйлчлүүлэгчид урт хугацаа шаардах тайвшруулах дасгалыг анх заахдаа сэтгэл хөдлөл тайван бус нөхцөлд заахаас зайлсхийгээрэй. Энэ тохиолдолд үйлчлүүлэгчид үр дүнгүй санагдаж, тайвшруулах дасгалд итгэх итгэл буурч, өөрийн сэтгэл хөдлөлийг зохицуулах сэдэл буурах эрсдэлтэй. Иймээс энэ тохиолдолд сэтгэл зүйч үйлчлүүлэгчтэй ярилцах арга, зургийн арга, богино хугацааны тайвшруулах амьсгалын дасгал, булчингийн дасгал зэрэг жижиг аргачлалуудаар ашиглаж үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлийг тогтворжуулна.

Үйлчлүүлэгчийн бие махбодыг бэлтгэх. Үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөл харьцангуй тогтвортой байгаа тохиолдолд тайвшруулах амьсгалын дасгал болон бусад дасгалыг зааварчилгааны дагуу хийлгэнэ. Дасгал хийлгэхийн өмнө болон дасгалын явцад үйлчлүүлэгчийн бие махбодыг тайван эсвэл тайван бус байгааг ажиглана. Дасгал бүрийн өмнө нийтлэгээр үйлчлүүлэгчийг 2 хөлийн улаар газарт бүрэн гишгэж, биеэ суллаж суухыг сануулдаг. Дасгал хийх явцад үйлчлүүлэгчид зовууртай байгаа эсэх, зааварчилгааны дагуу ажиллахад хүндрэлтэй байгаа эсэхийг ажиглаарай. Хэрэв таагүй байгаа мэт ажиглагдвал дасгалыг зогсоож болохыг сануулаарай.

Сэтгэл зүйн тест болон проектив аргуудыг ашиглаж үнэлгээ хийх явцад анхаарах:

- Тест болон бичих шаардлагатай үнэлгээний аргыг ашиглах тохиолдолд үйлчлүүлэгч унших, бичих боломжтой бол өөрөөр нь ажиллуулахыг санал болгоно. Хэрэв боломжгүй бол сэтгэл зүйч асууж, ярилцах замаар хариултыг бичнэ. Ингэхдээ байцаалт авч байгаа мэт асуултууд тавих, асуултын агуулгаас гажсан тайлбар хийхгүй байх, үйлчлүүлэгчийн хариултыг чиглүүлэхгүй байх зэргийг мэргэжилтэн анхаарна.
- Хөтөлбөрт багтсан проектив аргуудыг ашиглахдаа үйлчлүүлэгчид картуудыг барьж үзэх, эргүүлж харах, зургуудад боловсруулалт хийх хугацааг олгоно. Проектив арга нь мэргэжилтнээс асуултыг оновчтой асуух, чиглүүлж ярилцах, эмпати чадвар зэргийг шаарддаг. Сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрт 2 болон 3 дахь уулзалтад проектив аргыг ашиглахыг санал болгосон бөгөөд эдгээр аргыг үйлчлүүлэгч, сэтгэл зүйч хооронд итгэлтэй харилцаа тогтсон тохиолдолд ашигладаг.

- Үйлчлүүлэгчид гэрийн даалгавар өгөх: Уулзалтын төгсгөлд дараагийн уулзалт хүртэл үйлчлүүлэгч өөрийн сэтгэцийн эрүүл мэнддээ анхаарч, сэтгэл хөдлөлөө тогтворжуулах зорилготой ажлуудыг гэрийн даалгаварт өгдөг. Үйлчлүүлэгчид даалгаврыг санал болгохдоо түүний санал, сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл, дэмжлэг үзүүлэх боломжтой хүмүүс байгаа эсэх, амьдарч буй орчны нөхцөл байдал зэргийг харгалзан даалгаврыг өгнө. Ихэвчлэн хөнгөн, богино хугацаа шаардах ажлуудаас урт хугацаа шаардах ажлууд руу бага зэрэг хүндрүүлж даалгаврыг өгнө. Үйлчлүүлэгч даалгаврыг гүйцэтгээгүй тохиолдолд хүндрүүлэхгүй байхыг анхаарах.

Тэмдэглэл хийх, хөтлөхтэй холбоотой анхаарах зүйлс:

Сэтгэл зүйн зөвлөгөөний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сэтгэл зүйн уулзалтын тэмдэглэлийн хуудас, сэтгэл зүйн үнэлгээний хуудас зэргийг хөтөлнө. Эдгээрийг хөтлөхдөө уулзалтын явцад өөрт сануулах үүднээс түлхүүр үг ашиглан тэмдэглэж, уулзалтын дараа түлхүүр үгсийг дэлгэрүүлэн бичихийг санал болгож байна. Учир нь үйлчлүүлэгчийн дэргэд байнга тэмдэглэл хөтлөх нь нээлттэй харилцаа үүсгэхэд хаалт болж болзошгүй.

Уулзалтын тэмдэглэлийн хуудас хөтлөх /Хавсралт 1/:

- Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл. Энэ хэсэгт хамгаалах байр, НЦҮТ-ийн журмын дагуу үйлчлүүлэгчийн кейсийг кодолж үйлчлүүлэгчийн код хэсэгт тэмдэглэнэ. Мөн үйлчлүүлэгчийн нас, хүйсийг тэмдэглэж, тухайн үйлчлүүлэгч ямар хүчирхийлэлд өртсөний улмаас хамгаалах байр, НЦҮТ-өөр үйлчлүүлэх болсныг ‘✓’ тэмдгээр тэмдэглэнэ.
- Үе шат, уулзалтын тэмдэглэл. Энэ хэсэгт хөтөлбөрт багтах уулзалт бүрийг явуулсан өдөр, уулзалтад ашиглаж буй сэтгэл зүйн арга техник, үнэлгээний үйл явц зэргийг тэмдэглэнэ. Мөн хамгаалах байр, НЦҮТ-ийн үйлчилгээний онцлогоос шалтгаалж дараагийн уулзалтыг өөр мэргэжилтэн чиглүүлэх боломжтой байдгийг харгалзаж дараагийн мэргэжилтэнд кейстэй хамааралтай анхаарах зүйл, сэтгэл зүйн арга аргачлалыг ашиглах явцад гарсан ажиглалт, үр дүнг тайлбар хэсэгт нарийн тэмдэглэж үлдээнэ.
- Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн. Энэ хэсэгт үйлчлүүлэгч сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдахаас өмнө хүчирхийллээс шалтгаалж (хүчирхийлэлтэй хамааралтай эсэхийг нарийн хэлэх боломжгүй тохиолдолд заавал хамааралтай байхыг шаардахгүй) бие махбод, сэтгэл зүй, зан үйлд илэрч буй шинж тэмдэг, өөрчлөлтийг сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх явцад уулзалт бүрийн дараа тэмдэглэнэ. Мөн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид гарч буй үр дүн, ажиглалт, ахиц, суралцаж буй үр чадвар, дадал зэргийг ‘үйлчлүүлэгчид гарсан сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн’ хэсэгт тэмдэглэнэ. Хамгаалах байр, НЦҮТ-ийн үйлчилгээний онцлогоос шалтгаалж урт хугацааны сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, тодорхой үр дүнд хүрэхэд хязгаарлагдмал байх тул үр дүн хэсэгт том өөрчлөлтийг бичихээс илүү тухайн уулзалтын явцад болон дараа үйлчлүүлэгчид сэтгэл хөдлөл, мэдрэмж, бодлын түвшинд гарч буй багахан өөрчлөлтийг ажиглаж бичихэд хангалттай. Энэ нь кейс бүртгэлд шаардлагатайгаас гадна сэтгэл зүйчийг ажлаас халшрах хам шинжид өртөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Сэтгэл зүйн үнэлгээний хуудас хөтлөх /Хавсралт 4/:

- Сэтгэл зүйн үнэлгээний хуудаст тухайн хөтөлбөрийн туршид ашиглах арга, аргачлалын зорилго, онцлог, бэлтгэх зүйлс, үйлчлүүлэгчид тайлбарлах зааварчилгаа, тухайн аргыг ашиглахад гарсан үр дүнг дараагийн уулзалт болон сэтгэл зүйн үйлчилгээнд хэрхэн ашиглах тухай товч оруулсан. Мөн тухайн арга аргачлалын явцад ашиглах хэрэглэгдэхүүн, ажлын хуудсыг хавсаргасан.
- Сэтгэл зүйч урьдчилан тухайн сэтгэл зүйн үнэлгээний аргуудтай танилцаж, бэлтгэл ажлыг хангаж, уулзалтад ашиглана.

НЭГ. АНХДАГЧ ХОЛБОО ТОГТООХ УУЛЗАЛТ



Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх:

- Гар самбар, бичгийн цаас, бал, Банхар карт, Ий күү карт, Уулзалтын тэмдэглэлийн хуудас / Хавсралт 1./
- Тайвшруулах амьсгалын дасгал, булчин суллах дасгалыг хэрхэн хийх зааварчилгаа бүхий бичлэг үзүүлэхэд бэлтгэсэн байх, амьсгалын дасгал хийхэд хэрэглэгдэх жижиг дэр бэлтгэх
- Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл /Хавсралт 2./



Уулзалтын зорилго:

- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдэд аюулгүй байдлын мэдрэмж өгөх, итгэж болох нээлттэй харилцааг тогтооход чиглэнэ.

АЛХАМ 1. Мэдээлэл авах, тодруулах /15 хүртэл минут/	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Асран хамгаалагч эсвэл мэргэжилтний хамт ирсэн тохиолдолд “Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл” (Хавсралт 2)-ийн хуудсыг тэмдэглүүлэн нөхцөл байдлыг дараах чиглэлээр тодруулна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл явдал хэзээ болсон? - Хүчирхийлэгч хүүхэдтэй ямар холбоотой, харилцаатай байсан бэ? - Хүүхэд одоогоор сэтгэл санааны хувьд, зан үйлийн хувьд ямар байгаа вэ? - Эрсдэлтэй үйлдэл хийсэн эсэх 	<ul style="list-style-type: none"> - Асран хамгаалагчаас нөхцөл байдлыг нарийвчлан тодруулах нь зүйтэй. - Ингэхдээ хүүхдийн хажууд мэдээллийг асуухгүй байхыг анхаарах - Урьдчилан мэдээллийг авсан байх нь ярилцлагыг зөв чиглүүлэхэд дөхөм болно.
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> - Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл (Хавсралт 2.) - Түр хамгаалах байр, НЦҮТ-ийн журам, үйлчилгээний маягтуудын дагуу гэрээ байгуулна. - Уулзалтын тэмдэглэлийн хуудасны дагуу тэмдэглэл хөтөлнө. 	

АЛХАМ 2. Харилцаа, холбоо үүсгэх / 15 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Мэргэжилтэн өөрийгөө танилцуулна.</p> <p>Өсвөр насны хүүхэдтэй сургууль, чөлөөт цаг, сонирхол, гэрийнхний талаар ердийн асуултаар яриагаа эхэлнэ. Ингэхдээ тухайн хэрэг гэр бүлийн орчинд үйлдэгдсэн бол сургуулийн талаар, харин сургуулийн орчинд үйлдэгдсэн бол гэр бүлийн талаар эхэлж ярилцана.</p> <p>Хүүхэд чимээгүй суух үед надтай ярилцахад бэлэн байна уу гэж асууж болно. Ярих гэж хичээж байх үед асуулт тавьж саад болж болохгүй.</p> <p>Мэргэжилтэн итгэж болохуйц санагдсан үед хүүхэд ярьж эхэлдэг.</p> <p>Дараах тохиолдолд булчин суллах дасгал хийлгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийн царай цонхийсон - Булчин чангарсан, биеэ чангалсан - Хөдөлгөөнгүй удаан суух - Ярих үед хоолой чичрэх, эрүү “зуурах” - Гарын хөлс гарах 	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийг өрөвдсөн өнгө аяс илэрхийлэх, хэт болгоомжилж харилцах нь мэргэжлийн биш харагдуулдгийг анхаарах - Биед нь хүрэх, нүд рүү нь хэт ширтэхээс зайлсхийх - Хүүхдийг яаруулалгүй, анхааралтай сонсох - Бэлгийн хүчирхийллийн талаар хүүхэд илэрхийлэх дургүй, айж ичдэгийг харилцаанд харгалзах - Хүүхэд айдас түгшүүрийн үед биед булчин чангарлын шинж тэмдгүүд илэрвэл /шинж тэмдгийн зааварчилгаа хэсгээс харах/ хамгийн түрүүнд булчинг суллах дасгал хийх нь үр дүнтэй. Ингэснээр булчин суларч бие махбодын хувьд амарч тайвширдаг. Бие махбод ингэж тайвшраагүй үед ярилцах нөхцөл бүрдэхгүйгээс гадна нүүр хөхрөх, амьсгалын дутагдалд орох, таталт өгөх, ухаан алдах гэх мэт ноцтой үр дагаварт хүргэх эрсдэлтэй байдаг.
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> - Уулзалтын тэмдэглэлийн хуудасны дагуу тэмдэглэл хөтөлнө. - Булчин суллах дасгал хийж тайвшруулна. Зааврыг Хавсралт 3-аас харна. 	

АЛХАМ 3. Мэдээлэл авах /15 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Тухайн үйл явдал хэзээ болсон, хэдэн удаа тохиолдсон, хүчирхийлэгч хэн байсан, одоо хэн хэнтэйгээ амьдардаг талаар ярилцана.</p> <p>Үүний дараа сэтгэл санаа, бие махбод, нийгмийн асуудлууд гэсэн 3 чиглэлээр мэдээлэл авна.</p> <p>Хүүхэд өөрийн мэдрэмжийн талаар тодорхой ярихыг хүсэхгүй, эсвэл илэрхийлж чадахгүй байгаа үед сэтгэл хөдлөлийг илэрхийлэх картыг ашиглаж болно.</p> <p>Ингэхдээ “Энэ зургуудыг хоёулаа өрж тавья. Аль зураг нь чиний сэтгэл санаатай ойр юм шиг санагдаж байна? 2 зураг сонгож болно” гэсэн заавар өгнө. Хүүхэд зургийг сонгосны дараа энэ зургийг харахад чамд ямар мэдрэмж төрж байна? Сэтгэл санаа нь ямар байгаа бол, биед юу мэдрэгдэж байгаа бол? Энэ үед харилцаа нь ямар байх бол гэсэн чиглэлээр ярилцана.</p>	<ul style="list-style-type: none"> - Хүүхдэд хэт олон асуулт дараалж тавьж болохгүй - Дасгал хийх үед болон хийсний дараа ямар мэдрэмж төрж байгаа талаар асуух - Өөрт тохиолдсон үйл явдлын талаар ярих хугацааг нэг удаагийн уулзалтад 11-12 насны хүүхдийн хувьд 10 минутаас илүүгүй, 13-14 настай хүүхдийн хувьд 15 минутаас илүүгүй, 15-17 хүртэл насны хүүхдэд 20 минутаас илүүгүй байхаар тооцох

Хэрэглэгдэхүүн / Арга барил
<ul style="list-style-type: none"> - ХНХЯ сайдын 2017 оны 04 сарын 20-ны өдрийн тушаалаар батлагдсан Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээний маягтын дагуу хохирогчийн одоогийн байдал, хохирогчид илэрч буй шинж тэмдгүүд гэсэн хэсгийн дагуу мэдээллийг авна. - Банхар карт, Ий күү карт, Шүхэр карт, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх бусад карт ашиглаж болно.

АЛХАМ 4. Тайвшруулах /10 хүртэл минут/	
Заварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Ойр дотно найзууд, юу хийхээр сэтгэл санаа сайхан байдаг талаар 2-3 асуулт асууна. Дүүтэй эсэх, дүүтэйгээ хэр ойр байдаг, хэр сахилгагүй зэрэг сэдэв байж болно. Ингэхдээ хүүхдэд хөндүүр санагдаж болзошгүй асуулт тавьж болохгүй.</p> <p>Энэ хэсэг ярилцлагын үеэр хүүхдийн сэтгэл санаа дээрдэх учиртай. Ингээд дараа дахин уулзана, тэр үеэр арай өөр сэдвээр ярилцахыг хүсэж байгаа талаараа хэлж эхний уулзалтыг өндөрлүүлнэ.</p> <p>Хүүхдэд дараах байдал ажиглагдвал амьсгалын дасгал хийлгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд айж түгшсэн байх - Хөдөлгөөнгүй, биеэ барьсан байх - Гунигтай харцтай байх - Уруулаа хазах - Гараа оролдож суух 	<p>Сэтгэл түгшилт айдас их байх, таагүй сэдвээр ярилцсаны дараа уулзалтыг шууд төгсгөж болохгүй. Ямар нэг эерэг мэдрэмж төрүүлээд яриаг дуусгана.</p> <p>Би чамайг ойлгож байна, бүх зүйл сайхан болно, санаа зоволтгүй зэрэг үг хэллэг хэрэглэхгүй байхад анхаарах хэрэгтэй.</p> <p>Сэтгэл зүйч нухацтай, өрөвдсөн харцаар харж хүүхдийг үдэж болохгүй.</p> <p>Мэргэжилтний дуу хоолой тайван, ажил хэрэгч, сайхан сэтгэлтэй өнгө аястай байх нь зүйтэй.</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> - Амьсгалын дасгал хийлгэж болно. 	

ХОЁР. СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ УУЛЗАЛТ



Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх:

- Гар самбар, бичгийн цаас, бал, Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./
- Сэтгэл зүйн тестүүд бэлдсэн байх, сэтгэл зүйн тестийн заавар, үр дүнг гаргах аргыг эзэмшсэн байх



Уулзалтын зорилго:

- Хүүхдэд тохиолдсон үйл явдалтай холбоотой сэтгэл зүйн үнэлгээ хийх,
- Хүүхдийн орчны эрсдэлийг үнэлэх
- Сэтгэл хөдлөлийн байдлыг илрүүлэх
- Хүүхдийн сэтгэл зүйн нөөцийг илрүүлснээр цаашид ямар аргаар ажиллах, ямар арга замыг санал болгохыг тодорхойлоход чиглэнэ.

АЛХАМ 1. Холбоо тогтоох /5 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
Сэтгэл санааны байдал, эсвэл одоо ямар мэдрэмж төрж байгаа талаар ярилцана. Эхний уулзалтаас хойш хэрхэн өөрчлөгдсөн байгааг анхааралтай ажиглана.	Хүүхдийн идэвх, ядралт ямар байгааг ажиглана.
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
- Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.	

АЛХАМ 2. Сэтгэл зүйн үнэлгээ хийх /20 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
Энэ хэсэгт хүүхдийн сэтгэл зүйн одоогийн байдал, айдас, түгшүүр, сэтгэцийн гэмтлийн үед үзүүлэх хариу үйлдэл ямар байгааг судална. Богино хугацааны, тусгалын шинжтэй тестүүдийг ашиглах нь тохиромжтой. Доорх тестүүдээс нийлэмжийн арга, PTSD илрүүлэх хурдавчилсан асуулгыг заавал авах шаардлагатай. Нийлэмжийн арга Хүүхдэд санаандаа орсон үгнүүдийг нэрлэх, эсвэл бичих даалгавар өгнө. Үг нэрлэх үед сэтгэл зүйч бичиж авна. Ойролцоогоор 60 үг нэрлүүлэх ёстой. Нүдэндээ ил харагдаж байгаа зүйл, тоо хэлэхгүйгээр аль болох хурдан нэрлэх талаар зааварчилгаа өгнө.	Тестийн зааварчилгаа болон асуулыг ойлгохгүй байх тохиолдолд асуултын хүрээнд тайлбар өгч болно. Тестийг авахдаа хугацаа заахгүй байх нь үйлчлүүлэгч өөрийнхөөрөө бодох, тайван байхад эерэг нөлөөтэй.

<p>PTSD илрүүлэх хурдавчилсан асуулга</p> <p>Нийт 7 асуулттай. Сүүлийн нэг сарын байдлыг бодож, тийм эсвэл үгүй гэсэн хариулт авна.</p> <p>Люшерийн өнгөний тест. Сэтгэл зүйн тухайн үеийн нөхцөл байдлыг илрүүлнэ. Үйлчлүүлэгч өөрт хамгийн аятайхан санагдсан өнгөнөөс таагүй харагдаж байгаа хүртэл дараалуулна. Үйлчлүүлэгчийн сонгосон дарааллаар компьютерийн програмд оруулж үр дүнг тооцно. / Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа болон өнгөний кодыг Сэтгэл зүйн үнэлгээний хуудас Хавсралт 2-ын 1 дугаарт оруулав./</p> <p>CRIES асуулга</p> <p>Нийт 13 асуулттай. Сэтгэл зүйн гэмтэл хүүхдэд хэр хүчтэй нөлөөлж буйг илрүүлэхэд чиглэсэн.</p>	
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> - Люшерийн өнгөний карт - Нийлэмжийн арга - PTSD хурдавчилсан арга - CRIES асуулга 	

АЛХАМ 3. Сэтгэл хөдлөлийн тухай ярилцах /15 хүртэл минут/	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн тухай ярилцана.</p> <p>Би..... үед маш их уурладаг</p> <p>Би үед хорсдог</p> <p>Би үед надад муухай санагддаг</p> <p>Би үед би баярладаг</p> <p>Би үед би тайван байдаг</p> <p>..... үе надад таалагддаггүй</p> <p>..... үе надад таалагддаг</p> <p>..... үе надад сайхан санагддаг</p> <p>Үүний дараа</p> <ul style="list-style-type: none"> - Би үедээ ингэдэг дээрх дарааллаар бичүүлнэ. - Бусад хүмүүс яадаг бол гэдгийг ярилцана. 	<p>Хүүхэдтэй холбоо тааруу тогтоосон бол ярилцах сонирхолгүй байж болно. Энэ тохиолдолд “Одоо ярилцах сонирхолгүй бол дараа үргэлжлүүлж ярилцаж болно. Тэр болтол дотроо бодож байгаарай” гэсэн байдлаар түр хойшлуулж болно. Тухайн үед хүүхэд яриагүй ч бодоод өнгөрдөг, дараа нь үргэлжлүүлэн бодох сэдлийг өгсөн тул дараагийн уулзалтаар лавлаж асуухад болно.</p> <p>Хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллах нь мэргэжилтний хувьд ч ялгаагүй хүнд байх нь элбэг бөгөөд үйлчлүүлэгчтэй ажиллахаас зайлсхийх үүднээс хойшлуулахгүй байхад анхаарах нь зүйтэй.</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<p>2-р баганад тэмдэглэгдсэн “Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн ярилцах загвар”</p>	

АЛХАМ 4. Баталгаажуулалт, дүгнэлт /5 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн тухай ярилцсаны дараа сэтгэл санааны байдал хэр байгааг ажиглаж, дараагийн уулзалт дээр дахин өөр сэдвээр ярилцахыг сануулаад яриаг өндөрлүүлнэ.</p> <p>Эхний 2 уулзалтын дараа сэтгэл зүйч дараах асуудлыг олж харсан байвал зохино.</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийн түвшин, нөөц чадавх ямар байна? - Муугаар нөлөөлж болох сэтгэл зүйн ямар шинжүүд илэрч байна? - Сэтгэл зүйн гэмтэл авах орчинд амьдарч байна уу? - Сэтгэл заслын ямар арга нөлөөлөх боломжтой байна? - Гэр бүлээс нь оролцох боломжтой ямар гишүүн байна? 	<p>Сэтгэл түгшилт айдас их байх үед болон таагүй сэдвээр ярилцсаны дараа уулзалтыг шууд төгсгөж болохгүй. Ямар нэг эерэг мэдрэмж төрүүлээд яриаг дуусгана. Ингэхдээ сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн талаар өөрөө ярилцсан бол баярладаг, тайван байдаг, таалагддаг зүйлсийн тухай сануулж, дараагийн уулзалт хүртэл эдгээр зүйлсээс хийж ирээд үргэлжлүүлэн ярилцана гэдгийг сануулна. Хэрвээ сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн талаар ярилцаагүй бол би / эгч нь чиний сэтгэл санааг хуваалцаж, бусадтай холбоо тогтооход чинь туслах хүсэлтэй байна. Дараагийн удаагийн уулзалт хүртэл юу хийвэл сэтгэл санаа тайван, аз жаргалтай болдог вэ? тэрийгээ хийгээд ирээрэй гэж уулзалтын өдрөө хэлж болно.</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
2-р баганад тэмдэглэгдсэн “Сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн ярилцах загвар”	

ГУРАВ. СЭТГЭЛ ХӨДЛӨЛ ТОГТВОРЖУУЛАХ



Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх:

- Гар самбар, бичгийн цаас, бал, метафор карт, Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./
- Метафор карттай танилцаж, ашиглаж туршсан байх.



Уулзалтын зорилго:

- Үйлчлүүлэгчийн сэтгэл санаа ямар байгааг тодруулах
- Үйлчлүүлэгчийн айдас түгшилт, ичгүүртэй санагдах гэх мэт сөрөг мэдрэмжийг бууруулахад чиглэнэ.

АЛХАМ 1. Сэргээн санах, харилцаа үүсгэх /10 хүртэл минут/

Зааварчилгаа

Өмнөх уулзалтуудаас олж авсан мэдээлэлд тулгуурлан сэтгэл хөдлөл тогтворжуулах аргыг сонгох нь зүйтэй.

Сэтгэл санааны байдал ямар байгаа талаар болон эерэг өөрчлөлт гарч байгаа эсэх талаар ярилцаж эхэлнэ.

Хэрэглэгдэхүүн / Арга барил

Уулзалт бүр дээр хөтөлж буй “Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх.

АЛХАМ 2. Метафор карт ашиглаж ярилцах /30 хүртэл минут/

Зааварчилгаа

Метафор картын тусламжтай ярилцах.

Сэтгэл хөдлөлийн “Банхар”, эсвэл “Ий күү” картын дагуу одоогийн сэтгэл хөдлөө илэрхийлэх карт сонгох, ямар үед таагүй сэтгэгдэл төрж байна, ямар мэдрэмж мэдрэхийг хүсэж байна, таатай мэдрэмж мэдрэхийн тулд юу хийж болох тухай картын дүрстэй холбон ярилцана.

Нэмэлтээр санал болгох карт: “Саванд анивчсан гал”

Энэхүү карт нь янз бүрийн хэлбэр бүхий ухмал хоосон дүрстэй картууд, сэтгэл санааны байдлыг илэрхийлж болох зургуудаас бүрдэнэ.

Анхаарах зүйлс

- Картыг бүтээлч байдлаар олон төрлөөр ашиглаж болох бөгөөд өнөөдрийн сэтгэл хөдлөл, нөхцөл байдлыг илэрхийлэхүүц картыг сонгож ярилцана.
- Сэтгэл зүйч картыг ашиглаж хүүхдийн сэтгэл санаа ямар байгааг, ямар болохыг хүсэж байгааг, үүндээ яаж хүрч болох талаар сэдэл өгч ярилцана.
- Энэхүү карт нь бие махбод, сэтгэл санаа ямар байгааг зургаар харуулах боломжтой.

<p>Ухмал дүрс бүхий картад одоогийн сэтгэл санааны байдлыг илэрхийлэх нэг карт, хүсэж буй сэтгэл санааны байдлыг дүрслэх нэг карт, цаашид юуг хийвэл илүү дээрдсэн байх вэ гэдэгт төвлөрч өөр нэг зураг сонгох гэх мэтээр хоосон дүрс бүхий картыг олон картаар дүүргэнэ. Ингэснээр үйлчлүүлэгч өөрийн одоогийн нөхцөл байдлыг ухаараад зогсохгүй цаашид юун дээр төвлөрөх, сэтгэл санаагаа ямар болгохоор хичээх вэ? гэх мэтээр өөрийн асуудал бэрхшээлийг ойлгож, хүлээн зөвшөөрч, зарим тохиолдолд юу хийх хэрэгтэй байгаагаа ч олж харж сэтгэл санааны тогтвортой, итгэлтэй байдлыг бий болгодог.</p>	
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
Метафор карт	

АЛХАМ 3. Дүгнэлт /10 хүртэл минут/	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Карттай ажиллах үед ямар байсан талаар, мөн өөрийн сэтгэл хөдлөлийг өөрчлөхийн тулд юу хийж болох талаар яриулна.</p> <p>Сэтгэл санаа хэцүү үед юу хийж болох талаар ярилцана.</p> <p>Сэтгэл хөдлөлөө өөрчлөхийн тулд хийж болох зүйлс болон сэтгэл санаа хэцүү үед юу хийж болох талаар ярилцсан зүйлсээс хүүхдэд эергээр нөлөөлөх 2-3 зүйлийг дараагийн уулзалт хийх хүртэл туршиж үзэхийг санал болгож гэрийн даалгавар өгнө.</p>	<p>Сэтгэл түгшилт айдас их байх үед болон таагүй сэдвээр ярилцсаны дараа уулзалтыг шууд төгсгөж болохгүй. Ямар нэг эерэг мэдрэмж төрүүлээд яриаг дуусгана.</p> <p>Ярилцлагын явцад үйлчлүүлэгчид чиглүүлэг болгож сэтгэл хөдлөлөө өөрчлөхийн тулд юу хийж болох, сэтгэл санаа хэцүү үед юу хийж болох талаар хүүхдийн онцлогт тохирсон аргуудыг санал болгож жишээ татаж өгнө.</p>
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
Ярилцлага	

УДААН ХУГАЦААНЫ СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ, СЭТГЭЛ ЗАСЛЫН ЭМЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ НӨХЦӨЛ

Хүүхдэд илэрч буй доорх шинжүүдээс 6 болон түүнээс дээш шинж илэрч байвал сэтгэл засалд хамруулах нь зүйтэй. Тод хараар тэмдэглэсэн шинжүүдийг эрсдэл өндөр шинжүүд гэж үзэж болно.

Хүүхдэд илэрч буй шинжүүд		Тийм бол ✓
1	Холбогдох байгууллагын зүгээс аюулын зэргийг дунд болон өндөр гэж үнэлсэн байх	
2	Люшерийн тестээр СО үзүүлэлт 6-7, ВК үзүүлэлт 1-2 байх	
3	Нийлэмжийн тестээр идэвх суларсан, сөрөг сэтгэл хөдлөл бүхий үг ихээр хэрэглэсэн, түүнчлэн утга учир, үнэ цэнэ алдагдсан үг хэрэглэх	
4	PTSD тестээр 4 түүнээс дээш оноо авах	
5	CRIES тестээр 30 түүнээс дээш оноо авах	
6	Бие махбодын сөрөг мэдрэмжүүд 2 уулзалтын дараа багасахгүй байх	
7	Сэтгэл санааны байдал дордож байгаа өгүүлэмжтэй байх	
8	Шөнө хар дарж зүүдлэх, үйл явдал дахин давтагдах юм шиг санагдаж байгаа талаараа өгүүлэх	
9	Хүчирхийлэл үйлдэгчтэй ойр байх	
10	Хэргийн явц шийдэгдэхгүй удаашрах	
11	Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдийг буруутгах	
12	Хүчирхийллийн улмаас жирэмсэлсэн, үр хөндүүлэх шийдвэр гаргаж байгаа, эсвэл хүүхдээ тээхээр шийдсэн	
13	Хүчирхийллийн улмаас эрүүл мэндийн байдалд хохирол учирсан өгүүлэмжтэй байх	

Хүүхдэд _____ эрсдэлт шинжүүд илэрч байгаа тул удаан хугацааны сэтгэл зүйн үйлчилгээ/ сэтгэл засал эмчилгээнд хамруулах саналтай байна.

Сэтгэл зүйч _____

Жич: Энэхүү хуудсыг үйлчлүүлэгчийн кейсэд хадгална. Шаардлагатай тохиолдолд холбон зуучилж буй байгууллагад илгээж болно.

ДӨРӨВ. АСРАН ХАМГААЛАГЧ, ЭЦЭГ ЭХТЭЙ ХИЙХ УУЛЗАЛТ



Уулзалтын өмнө хэрэглэгдэхүүнийг бэлтгэх:

- Гар самбар, бичгийн цаас, бал, Уулзалтын тэмдэглэлийн хуудас /Хавсралт 1./



Уулзалтын зорилго:

- Эцэг эхэд хүүхдийн сэтгэл зүйн үнэлгээг танилцуулах
- Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхэдтэйгээ хэрхэн холбоо тогтоох талаар мэдээлэл өгөх
- Сэтгэл зүйн боловсрол олгоход чиглэнэ.

АЛХАМ 1. Холбоо тогтоох /10 хүртэл минут/	
Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Сэтгэл зүйч өөрийгөө танилцуулна.</p> <p>Болсон үйл явдлын дараа ямар мэдрэмж төрсөн, цаашид яах бодолтой байгаа талаар ярилцана. Хүүхдийн сэтгэл санаа, биеэ авч байдал, идэвх сонирхол ямар байгаа талаар асууна.</p> <p>Эцэг эх, асран хамгаалагчид дараах шинжүүд анзаарч буй эсэхийг анхааралтай ажиглана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Санаа зовнисон байдал бага байх - Архины хамааралтай байж болзошгүй - Сэтгэцийн тулгамдсан асуудалтай байж болзошгүй - Хүүхдийг буруутгах хандлага ажиглагдах - Хүүхэдтэй хөндий харилцаатай байж болзошгүй <p>Дээрх шинжүүд илэрч байгаа бол хүүхдийн талаар мэдээллийг ямар түвшинд өгөхөө шийднэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх өөрсдөө сэтгэл зүйн хувьд төлөвшөөгүй, ширүүн харилцаатай байх - Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн хувьд танил тал, хамаатан садны хүрээнд тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн байх нь элбэг байдаг. Эцэг эх, асран хамгаалагчид өөрсдийн нэр хүндийг бодох, бусдаас ичих зэрэг асуудлаас үүдэлтэй нууцлаад өнгөрөх сонирхол байдгийг харгалзан үзэх нь зүйтэй.
Хэрэглэгдэхүүн / Арга барил	
<ul style="list-style-type: none"> - Уулзалт бүр дээр хөтөлж буй “Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ыг үргэлжлүүлэн бөглөхөд бэлдэх. 	

АЛХАМ 2. Мэдээлэх /25 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<ul style="list-style-type: none"> - Эцэг эхэд хүүхдийн сэтгэл санааны байдал, илрэл, үр дагаврын талаар - Хүүхдийн сэтгэл зүйн үнэлгээг тайлбарлах - Хүүхдийг ажиглаж байх - Сэтгэл санаа тайван бус үед нь болон цаашид хэрхэн харилцаж байх талаар мэдээлэл өгнө. <p>Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс таагүй хандлага илэрч байгаа тохиолдолд хүүхдийн талаар сөрөг мэдээллүүдийг хэлэх нь эргээд хүүхдэд сөргөөр нөлөөлөх нөхцөл болдгийг анхаарах нь зүйтэй.</p> <p>Хүүхдэд илэрч буй шинжүүдийг ажиглах:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл явдал болсноос хойш 3-6 сарын хугацаа өнгөрсөн ч хүүхэд үг дуу цөөтэй байх, нийгмийн амьдралд идэвх оролцоо сул байх, үхэх тухай ярих, өөрөөсөө ах хүүхдүүдтэй нийлэх, шөнө оройн цагаар гадуур тэнэх нь ихсэх, гэр орноосоо дайжих, гарын шуунд зүслэг хийх, нойронд муу байх, айдас ихсэх, түрэмгий зантай болох, хичээлд эрс муудах, түүнчлэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн байдлыг анхаарч байх хэрэгтэй. Эдгээр шинжүүд илрэх үед холбогдох мэргэжлийн хүмүүсээс цаг алдахгүй тусламж авах шаардлагатайг сануулна. Энэ үед эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хайнга байдлаар хүлээж авах, эсэргүүцэх, асуулт асуухгүй байх зэрэг үед 2 долоо хоногийн дараа давтан уулзах хүсэлт тавьж, хүүхдэд илэрч буй асуудлуудын талаар ярилцах нь зүйтэй. - Хүүхэдтэй харилцах талаар дараах зөвлөмжийг өгнө. Үүнд: - Хүүхдийн дэргэд нөхцөл байдлыг дахин дахин сэдэрээж ярихгүй байх - Хүүхдийг буруутгах, ичгүүртэй мэдрэмж төрүүлэхгүй байх - Хүүхдийн аюулгүй байдлыг харгалзах - Болсон үйл явдлаар дарамтлах, тулгахгүй байх <p>Хүүхдэд тайвшруулах арга зааж өгөх</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийг өрөөнөөс гаргаж дуртай зүйлийг нь хийлгэх - Намуухан аятай хөгжим асаах - 10 удаа гүнзгий амьсгалах - Суугаад, нүдээ аниад, өөрийн дуртай газраа төсөөлөх г.м. 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхийг буруутгасан өнгө аяс илэрхийлэхгүй байх - Сэтгэл санааг хэт хямрахаас зайлсхийнэ. - Тууштай анхаарах шаардлагатайг ойлгуулахыг эрмэлзэх хэрэгтэй. - Хуулийн байгууллагаар явж байгаа хэргийн процесстой танилцаж хүүхдээ тухайн хэрэг дээр ажиллаж байгаа хүмүүстэй холбогдох үед нь хамт дагуулж очих, өөрөө давхар мэдээлэл авч байх гэх мэтээр ганцаараа биш, хамгаалагдаж байгаа гэсэн мэдрэмжийг төрүүлэхэд анхаарахыг эцэг эхэд сануулах

АЛХАМ 3. Дүгнэлт /15 хүртэл минут/

Зааварчилгаа	Анхаарах зүйлс
<p>Хүүхдийн сэтгэл зүйн байдалд анхаарах нь хожуу илрэх үр дагаврыг багасгах боломжтой. Асуух зүйл байгаа эсэхийг тодруулна.</p> <p>Хүүхдийнхээ төлөө ойрын 2 долоо хоногт юу хийх боломжтой талаар сонирхож асууна. Хүссэн үедээ хүүхэдтэйгээ цуг ирж болох тухай сануулснаар уулзалт дуусна.</p>	<p>Эцэг эх нь мөн энэ хэрэгт өөрийгөө буруутгах гэх мэтээр дам хохирогч болдог тул өөрсдөд нь ч сэтгэл санааны дэмжлэг үзүүлж дахин холбогдоход хэзээд нээлттэй гэсэн мэдрэмжийг төрүүлэхэд анхаарах</p>

Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх

Хөтөлбөрийн үр дүнг Хавсралт 1. “Уулзалтын тэмдэглэлийн хуудас”-ын дагуу үйлчлүүлэгчтэй хийх уулзалт бүрийн явцад хөтөлнө. Үүнд:

- Эхний сэтгэл зүйн уулзалтын дараа ‘Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл’,
- Уулзалт бүрийн явцад ‘Үе шат, уулзалтын тэмдэглэл’

Дөрөв дэх уулзалтын төгсгөлд ‘Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн’ хэсгийн дагуу тэмдэглэл хийж, үйлчлүүлэгчид үзүүлсэн сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн, ахицыг үнэлнэ.

ТУЛГАРЧ БОЛОХ БЭРХШЭЭЛ, ДАВАН ТУУЛАХ СТРАТЕГИ

Тулгарч болзошгүй бэрхшээл	Даван туулах стратеги
<p><i>Хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон гэр бүлийнхэн бэлгийн хүчирхийллийн тухай алдаатай бололтой байх үед яах вэ?</i></p>	<p>Хүүхдийн эсрэг үйлдэгддэг бэлгийн хүчирхийллийн талаар хүмүүсийн дунд нийтлэг гардаг буруу, ташаа ойлголт цөөнгүй байдаг. Үүнд: Хүүхэд зохиож худлаа ярьдаг, хүүхдийн хувцаслалт биеэ авч яваа байдал хөнгөн, өдөөн хатгасан шинжтэй байдаг, танихгүй эрэгтэй хүн л аюултай, хүүхдээ хамгаалаагүй ээж буруутай гэх мэт.</p> <p>Анхаар: Хүүхэд болон гэр бүлийнхэн өөрийгөө буруутгаж байгаа үед хүүхэд өөрт тохиолдсон ийм зүйлийг бүрэн ярих дургүй байдаг. Тиймээс хүүхэд ярьж эхэлсэн бол итгэх хэрэгтэй. Түүнчлэн бага насны хүүхэд бэлгийн зан үйлийн талаар мэдлэггүй тул энэ талаар ярьсан л бол итгэж ярилцах хэрэгтэй. Мөн зарим тохиолдолд ээж нар гэр бүлийн хүчирхийллийн хохирогч байдаг тул хүүхдээ хамгаалах чадваргүй байдаг. Таньж мэддэг ураг төрлийн хүмүүс хүчирхийлэгч байх тохиолдол байдаг тул хүүхэд айж ичсэнээс болж эсвэл гэр бүлийнхэнд чинь муу зүйл хийнэ гэж айлгаж сүрдүүлсэн байдаг тул гэр бүлийнхнээ хамгаалж байгаа гэсэн сэдлээр хэлдэггүй тохиолдлууд байдаг гэдгийг ээжүүдэд, гэр бүлийн бусад гишүүдэд ойлгуулах хэрэгтэй.</p>
<p><i>Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай нь ажиглагдаж байгаа хэдий ч үйлчлүүлэгч сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдахыг хүсэхгүй байгаа тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үйлчилгээний зорилго, ач холбогдол, үр дүнг нас, сэтгэхүйн онцлогт нь тохиромжтой байдлаар тайлбарлаж өгнө. Хэрэв үйлчлүүлэгч өмнөх сэтгэл зүйн үйлчилгээнээс шалтгаалж мэргэжилтэнд итгэх итгэл буурсан бол үйлчилгээнд баримтлах хил хязгаар, ёс зүйн хэм хэмжээг тайлбарлаарай. Сэтгэл зүйч үйлчилгээг хангалттай тайлбарлаж чадсан хэмээн үзвэл үйлчлүүлэгчид шийдвэр гаргах боломжийг олгоорой.</p> <p>Анхаар: Үйлчлүүлэгчид үр дүнг тайлбарлахдаа амлалт өгөхөөс зайлсхийгээрэй. Үүний оронд үйлчилгээний явцад ямар эерэг үр дүнд чиглэх, үүний тулд хэрхэн хамтран ажиллах тухай тайлбарлаарай.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчийн үг, үйлдэлд огт хариу үйлдэл үзүүлэхгүй байвал яах вэ?</i></p>	<p>Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал, харилцааны онцлог, сэтгэл зүйн цочрол, түүний илрэл зэрэг олон зүйлсээс хамаарч зан үйл, хариу үйлдэл шалтгаална. Иймээс үйлчлүүлэгчийн чимээгүй байх, сэтгэл зүйчид харилцан үйлдэл үзүүлэхгүй байх нь үйлчилгээг хүсэхгүй байна гэсэн илэрхийлэмж болохгүй. Иймээс сэтгэл зүйч өөр өөр арга техникийг үйлчлүүлэгчид санал болгож, хэт тулгаж, яарахгүйгээр үйлчилгээг үргэлжлүүлээрэй. Зарим үед үйлчлүүлэгчтэй хамт чимээгүй суух, ямар нэгэн зүйлсийг ажиглах, зураг зурах, сараачих зэргээр идэвхтэй биш аргуудыг ашиглаарай.</p> <p>Анхаар: Үйлчлүүлэгчийн идэвхгүй байдлыг үйлчилгээнээс татгалзаж байна хэмээн дүгнэлт хийж, үйлчилгээг зогсоож болохгүй бөгөөд хариу үйлдэл бүр ялгаатай байж болно гэдгийг санаарай.</p>

<p><i>Үйлчилгээнд ашиглаж буй арга техник үйлчлүүлэгчид таагүй мэдрэмж төрүүлж байгаа тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Үйлчилгээнд ашиглаж буй арга, аргачлалын явцад болон дараа үйлчлүүлэгчид ямар санагдсан тухай асууна. Хэрэв түүний бие махбодод таагүй мэдрэмж төрүүлсэн, тааламжгүй бодлыг үүсгэсэн бол тухайн мэдрэмж, сэтгэл хөдлөлийн тухай дэлгэрүүлж ярилцах, тухайн мөчид болон одоод хэрхэн мэдрэгдэж байгаа тухай асуугаарай.</p> <p>Анхаар: Зарим дасгал ажлыг хийх үед үйлчлүүлэгчийн сэтгэцийн гэмтэл сэдэрч болзошгүй тул юу сэдэрэж байна гэдгийг ажиглаж дахин давтагдахаас зайлсхийгээрэй. Мөн үйлчлүүлэгчийн сэтгэцийн гэмтлийг сэдэрэж болзошгүй зүйлс, нөхцөл, сэдэрэх мөчид хэрхэн өөрийгөө тайвшруулах тухай сэтгэл зүйн боловсрол олгоно.</p>
<p><i>Хөтөлбөрт дурдсан арга техникийг ашиглах, сэтгэл зүйн үнэлгээг хийлгэхээс татгалзсан тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Хэрэв үйлчлүүлэгч сэтгэл зүйчийн санал болгосон арга техникийг ашиглахаас татгалзсан тохиолдолд түүнд боломжит сонголтуудыг олгож, нээлттэй асуух байдлаар үйлчилгээг үргэлжлүүлнэ.</p> <p>Анхаар: Үйлчлүүлэгчид тулгах, үүнээс өөр арга байхгүй мэт шаардах зэрэг нь сэтгэл зүйчид итгэх итгэлийг бууруулдаг. Хэрэв сэтгэл зүйчид өөр санал болгох арга техник байхгүй бол үйлчлүүлэгчид үнэн байдлаа хэлж дараагийн уулзалт дээр бэлтгэлтэй байхын тулд юу хийхийг хүсэж байгааг нь асууж ярилцана.</p>
<p><i>Үйлчлүүлэгч сэтгэл зүйчид хэт дасах, хамааралтай байдал ажиглагдсан тохиолдолд яах вэ?</i></p>	<p>Нэг талаар сэтгэл зүйч үйлчилгээ үзүүлэхдээ ёс зүйн зарчим дахь хил хязгаарыг хангалттай баримтлаагүй тохиолдолд, нөгөө талаар хүчирхийллийн даван туулагчийн сэтгэл зүйн онцлогоос шалтгаалж сэтгэл зүйчид дасах байдал ажиглагдаж болно. Энэ тохиолдолд сэтгэл зүйч үйлчилгээнд хил хязгаарыг баримталж, хувийн харилцаа биш мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгааг үйлчлүүлэгчийн насны онцлогт тохирсон байдлаар ойлгуулна. Мөн уулзалт бүрийн дараа даалгавар өгөх, уулзалтын хугацааг тогтмолжуулах, сэтгэл зүйчгүйгээр сэтгэл зүйн асуудлаа даван туулах дадлыг бэхжүүлэхийг хичээнэ.</p>

УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУУДАС

1. Үйлчлүүлэгчийн товч мэдээлэл

Үйлчлүүлэгчийн код:	_____
Нас, хүйс:	_____, _____
Хэрэгжүүлж буй хөтөлбөр	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр

2. Үе шат, уулзалтын тэмдэглэл

№	Арга, техник	Тэмдэглэгээ	Тайлбар																				
Уулзалтын үе шат: Код 5-1		Огноо: _____ / _____ / _____																					
1	Асран хамгаалагчаас тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл авсан эсэх	- Тийм - Үгүй																					
2	Булчин суллах дасгал хийсэн эсэх	- Тийм - Үгүй																					
3	Амьсгалын дасгал хийсэн эсэх	- Тийм - Үгүй																					
4	Метафор карт ашигласан эсэх	- Тийм - Үгүй																					
5	Удаан хугацааны сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэл засал эмчилгээнд хамруулах шаардлагатай эсэх, үндэслэл																						
Уулзалтын үе шат: Код 5-2		Огноо: _____ / _____ / _____																					
1	Өнгөний тест <table border="1" style="margin: 5px 0;"> <tr> <td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td> </tr> <tr> <td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td><td> </td> </tr> </table> 0 – саарал, 1 – хөх, 2 – ногоон, 3 – улаан, 4 – шар, 5 – ягаан, 6 - бор, 7 - хар																						
2	Нийлэмжийн арга																						
3	PTSD хурдавчилсан асуулга																						
4	CRIES асуулга (30 болон түүнээс дээш байх тусам сэтгэл зүйн гэмтэл хүнд байгааг харуулна.)	Огноо: _____																					
5	Удаан хугацааны сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэл засал эмчилгээнд хамруулах шаардлагатай эсэх, үндэслэл																						

Уулзалтын үе шат: Код 5-3		Огноо: ____ / ____ / ____	
1	Сэтгэл хөдлөлийн карт ашигласан эсэх / карт тэмдэглэх	- Тийм - Үгүй	
2	Сэтгэл хөдлөлийн картыг ашиглаж ярилцах үед үйлчлүүлэгчийн зүгээс гаргасан саналыг дараах 3 бүлгээр ангилж тэмдэглэнэ үү.	Одоогийн сэтгэл санааны байдал	
		Ямар болохыг хүсэж байгаа	
		Түүндээ хүрэхийн тулд юу хийх хэрэгтэй байна?	
Уулзалтын үе шат: Код 5-4		Огноо: ____ / ____ / ____	
1	Эцэг эхэд хүүхдийн сэтгэл санааны байдал, илрэл, үр дагаврын талаар тайлбарласан эсэх		
2	Хүүхдийн сэтгэл зүйн үнэлгээг тайлбарласан эсэх		
3	Сэтгэл санаа тайван бус үед нь болон цаашид хэрхэн харилцаж байх талаар мэдээлэл өгсөн эсэх		

3. Сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн

Хүчирхийллээс шалтгаалж үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт		
Бие махбодод гарсан өөрчлөлт	Сэтгэл зүйд гарсан өөрчлөлт	Зан үйлд гарсан өөрчлөлт
Үйлчлүүлэгчид гарсан сэтгэл зүйн үйлчилгээний үр дүн		
Бие махбод, сэтгэл зүй, зан үйлд гарсан эерэг үр дүн	Сэтгэл зүйн үйлчилгээний явцад суралцсан чадвар, итгэл үнэмшил, ахиц	Мэргэжилтний дүгнэлт болон үйлчлүүлэгчийн сэтгэгдэл

ХАВСРАЛТ 2.

АСРАН ХАМГААЛАГЧААС ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТАЛААР ТАНИУЛСАН ЗӨВШӨӨРӨЛ

Сэтгэл зүйн зөвлөгөөний онцлог: Үйлчлүүлэгчид тулгарсан асуудлаас үүдэлтэй сөрөг зан үйл, сөрөг бодлуудыг эергээр өөрчлөхөд туслах, нөхцөл байдлыг бодитойгоор хүлээн авч, үйлчлүүлэгч түүнийг даван туулахад сэтгэл зүйч хамтран ажиллана.

- Үйлчлүүлэгч сэтгэл зүйчтэй хамтран ажиллаж, асуудлаа тодорхойлж, гарцаа хайх, шийдвэрлэх эрхтэй бөгөөд сэтгэл зүйн зөвлөгөөг авахаас татгалзах эрхтэй.
- Асуудал, бэрхшээлийг мэргэжлийн түвшинд тодорхой үе шаттайгаар явуулж, цаашид авч болох арга замуудыг хамтдаа шийднэ.

Нууцлал: Өгсөн мэдээллийг сэтгэл зүйч мэргэжлийн ёс зүйн хүрээнд чандлан нууцлах үүргийг хүлээнэ.

Сэтгэл зүйн зөвлөгөөний зорилго: Хүүхдэд тулгамдсан асуудал, гэр бүлийн болон бусад орчны харилцаанд үүсэж буй асуудал, насны онцлогоос шалтгаалсан сэтгэл зүйн асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Сэтгэл зүйн зөвлөгөөний явц:

Нэг. Анхдагч холбоо тогтоох уулзалт

Хоёр. Сэтгэл зүйн үнэлгээ хийх уулзалт

Гурав. Сэтгэл хөдлөл тогтворжуулах уулзалт

Дөрөв. Асран хамгаалагч, эцэг эхтэй хийх уулзалт гэсэн 4 үе шаттайгаар явагдана.

Үргэлжлэх хугацаа: Тухайн үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлаас хамааран сэтгэл зүйн зөвлөгөөний уулзалтын тоо 4 болон түүнээс дээш удаа явагдана. Нэг удаагийн уулзалт 60 хүртэл минут үргэлжилнэ.

Зөвшөөрлийн маягт

Миний бие _____ овогтой _____ сэтгэл зүйн зөвлөгөөний тухай мэдээлэлтэй танилцсан. Тиймээс өөрийн хүү / охин / асран хамгаалж буй хүүхэд болох _____ -г сэтгэл зүйн зөвлөгөөнд оролцохыг зөвшөөрч байна.

Гарын үсэг _____ Огноо _____

ТАЙВШРУУЛАХ АМЬСГАЛЫН ДАСГАЛЫН ЗААВАРЧИЛГАА

1. Эверлийн амьсгалын дасгал

Зорилго: Богино хугацаанд тайвшруулах, стрессийн түвшин багасгахад чиглэнэ.

Онцлог: Стрессийн түвшин багасгаж, тайвшруулахад чиглэсэн богино хугацааны арга бөгөөд 3-5 минутад үр дүн өгдөг гэж үздэг.

Бэлтгэл: Амьсгалын дасгал хийж буй бичлэг үзүүлж болно. Бичлэг үзүүлэх боломжгүй тохиолдолд сэтгэл зүйч эхний удаа дараах алхмын дагуу зааж өгөх нь зүйтэй.

Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа буюу дасгал хийх алхам:

Амьсгалын дасгалын хувилбар 1

Алхам 1. Амьсгалаа 3 секундийн турш авна. Ингэхдээ хэвлий дээр гараа тавьж байгаад шаар үлээх үед хий орж байна гэж төсөөлнө.

Алхам 2. Амьсгалаа 2-3 секунд барина.

Алхам 3. Амьсгалаа 3 секундийн хугацаанд аажмаар гарна.

Дасгалыг 3-5 минут хийнэ. Дасгалыг хийж хэвших нь ач холбогдолтой талаар хүүхдэд тайлбарлаж өгнө.

Амьсгалын дасгалын хувилбар 2

Алхам 1. Баруун гарын эрхий хуруугаар хамрын нэг нүхийг дарж, урт амьсгаа авна.

Алхам 2. Долоовор хуруугаараа хамрын нөгөө нүхийг таглаад амьсгаа гаргана.

Алхам 3. Амьсгал аваад эргээд эрхий хуруугаар нөгөө талын хамрын нүхийг дарж, амьсгал гаргана гэх мэтээр дасгалыг 5-10 минут үргэлжлүүлнэ. Дасгалыг тавгүй үедээ хийж хэвших нь ач холбогдолтой талаар сануулна.

2. Булчин суллах дасгал

Зорилго: Сэтгэл санаа түгшсэн, яарсан, тавгүй үед булчин чангарсан байдаг. Энэ арга нь богино хугацаанд булчинг суллаж, бие махбод, сэтгэл санаа тайвшруулахад чиглэнэ.

Онцлог: Богино хугацааны үйлчлэлтэй. Ямар ч орчинд хийх боломжтой. Булчингаа суллаж сурах нь сэтгэл түгшилтийг бууруулах төдийгүй биеийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө

Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа буюу дасгал хийх алхам:

Алхам 1. Дөрөв хүртэл тоолох хугацаанд булчинг аажмаар чангалах бөгөөд дөрөв гэсэн тоо хүрэхэд булчинг дээд цэгт нь тултал чангалсан байна.

Алхам 2. Дахин дөрөв хүртэл тоолох хугацаанд булчинг чангалсан чигээрээ барина.

Алхам 3. Дахин дөрөв хүртэл тоолж, энэ хугацаанд булчингаа суллана.

Алхам 4. Булчин суллах дасгалыг эхлээд баруун гар, зүүн гар, баруун мөр, зүүн мөр, баруун хөл, зүүн хөл, хүзүү, нүүрний булчинг чангалж суллах дарааллаар хийнэ.

СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

(Сэтгэл зүйчийн ажлын хуудас)

1. Нийлэмжийн сорил

Заавар:

Санаандаа орсон үгнүүдийг аль болох бодолгүй, түргэн нэрлэнэ үү. Яг одоо ил харагдаж байгаа зүйлс болон тоо биш байх, бичсэн үгээ тоолох шаардлагагүй. 60 болсон байх гэсэн үедээ зогсоорой. (Ойролцоогоор 50-60 үг бичүүлнэ, эсвэл нэрлүүлж, сэтгэл зүйч бичиж авна)

Үр дүнг боловсруулах. Дараах үзүүлэлтүүдийн дагуу дүгнэнэ.

№	Агуулга	Бага	Дунд	Өндөр
1	Үг нэрлэх, бичих хурд			
2	Сэтгэл хөдлөл шингэсэн үг, эерэг, сөрөг агуулга бүхий үг хэр их байна			
3	Тэмдэг нэр хэр их ашигласан байна			
4	Хүнтэй холбоотой үг			
5	Амиа хорлох төлөвлөгөө, хэрэглэгдэхүүн гэж үзэж болох үг хэр байна			
Ерөнхий үнэлгээ '✓' тэмдэглэгээг хийнэ үү.				

2. Люшерийн өнгөний тест

Зорилго: Шинжлүүлэгчийн сэтгэл санааны тухайн үеийн байдал, ядралт, идэвх зэргийг илрүүлнэ.

Онцлог: Богино хугацаанд үр дүн гарах ба баталгаат чанар өндөртэй тусгалын арга болно.

Бэлтгэл: Гар өнгө, компьютерийн програм

Үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа: Энд байгаа өнгөнүүдийг хараад өөрт аятайхан санагдаж байгаа дарааллаар өрнө үү. 1 минут орчмын дараа дахин сонголт хийлгэнэ. Ингэхдээ өмнө өрснөөс өөр байж болох талаар анхааруулна. Хариулыг уулзалтын тэмдэглэлийн хуудсанд тэмдэглэж авна.

Өнгөний код: Саарал 0, хөх 1, ногоон 2, улаан 3, шар 4, хүрэн ягаан 5, бор 6, хар 7

Үйлчлүүлэгчийн сонгосон өнгөний дарааллыг компьютерийн програмд оруулж үр дүнг тооцно.

Үр дүнг сэтгэл зүйн үйлчилгээнд ашиглах:

Люшерийн тестийн үр дүнг үйлчлүүлэгчийн сэтгэл санааны байдлын талаар мэдээлэл авах, ярилцлага өрнүүлэх зорилгоор ашиглана. Үйлчлүүлэгч ядралт их, идэвх суларсан, нойрны асуудалтай байх зэрэг үед цаашид ажиллах чиглэлийг тодорхой болгох ач холбогдолтой.

3. PTSD хурдавчилсан асуулга

Заавар: Сүүлийн нэг сард танд дараах байдлуудаас илэрсэн үү? Зөв буруу, сайн муу хариулт гэж байхгүй тул та өөрийн мэдрэмжид тулгуурлан хариулт өгнө үү.

№	Асуулт	Тийм	Үгүй
1	Ямар нэгэн зүйлийг эргэн дурсахгүйн тулд тодорхой газар орон, хүмүүс болон үйл ажиллагаанаас зайлсхийдэг үү?		
2	Урд нь таатай, хөгжилтэй санагдаж байсан зүйл одоо сонирхолгүй санагдах болсон уу?		
3	Хүмүүсээс зай авч, хол баймаар санагдах болсон уу?		
4	Бусдад сэтгэл татагдах, хайрлах мэдрэмж багассан мэт санагдах болсон уу?		
5	Ирээдүйгээ төлөвлөх нь утгагүй санагдаж байна уу?		
6	Энэ явдлын дараа та өмнөх шигээ унтаж чадахгүй, эсвэл унтахад хэцүү байх болсон уу?		
7	Ердийн дуу чимээ, хэн нэгний хөдлөх чимээнээс амархан цочих болсон уу?		

Нийт оноо: _____

4 ба түүнээс дээш асуултад тийм гэж хариулсан бол сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн шинж илэрч байх боломжтой гэж үзнэ.

4. CRIES асуулга

Заавар: Сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд дараах байдлууд хэр байгааг бодож хариулаарай.

	Сүүлийн 2 долоо хоногт	Үгүй	Ховор	Хааяа	Байнга
1	Тэр үйл явдлыг дурсаагүй байхад хар аяндаа санаанд орж ирээд байна уу?	0	1	3	5
2	Тэр үйл явдлыг ой санамжаасаа бүрмөсөн арилгамаар санагдаж байна уу?	0	1	3	5
3	Анхаарал төвлөрөхөд хэцүү болсон уу?	0	1	3	5
4	Тэр үеийн мэдрэмж үе үе хүчтэй орж ирдэг үү?	0	1	3	5
5	Үйл явдал болж өнгөрсний дараа илүү их амархан цочиж тавгүйтэх болсон уу?	0	1	3	5
6	Энэ тухай дурсахгүй байхыг хичээж байна уу?	0	1	3	5

7	Үйл явдлыг санагдуулах газар орон, нөхцөл байдлаас зайлсхийж байна уу?	0	1	3	5
8	Тэр талаар оюун санаандаа дүрслэн боддог уу?	0	1	3	5
9	Бусад юмс тэр талаар бодоход хүргэж байна уу?	0	1	3	5
10	Тэр талаар бодохгүй бахыг хичээж байна уу?	0	1	3	5
11	Амархан бухимдаж уцаарлах болсон уу?	0	1	3	5
12	Жирийн үед ч сэрэмжлээд байх болсон уу?	0	1	3	5
13	Нойр хямрах болсон уу?	0	1	3	5

Нийт оноо: _____

30, түүнээс дээш байх тусам сэтгэл зүйн гэмтэл хүнд байгааг харуулна.

СЭТГЭЛ ЗҮЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

(Үйлчлүүлэгчийн ажлын хуудас)

Үйлчлүүлэгчийн код:

Үйлчлүүлэгчийн нас:

Үйлчлүүлэгчийн хүйс:

1. Нийлэмжийн сорил

Заавар:

Санаандаа орсон үгнүүдийг аль болох бодолгүй, түргэн нэрлэнэ үү. Яг одоо ил харагдаж байгаа зүйлс болон тоо биш байх, бичсэн үгээ тоолох шаардлагагүй. 60 болсон байх гэсэн үедээ зогсоорой. (Ойролцоогоор 50-60 үг бичнэ, эсвэл нэрлэнэ)

2. Люшерийн өнгөний тест

Зааварчилгаа: Энд байгаа өнгөнүүдийг хараад өөрт аятайхан санагдаж байгаа дарааллаар өрнө үү.

Өнгөний код: Саарал 0, хөх 1, ногоон 2, улаан 3, шар 4, хүрэн ягаан 5, бор 6, хар 7

3. PTSD хурдавчилсан асуулга

Заавар: Сүүлийн нэг сард танд дараах байдлуудаас илэрсэн үү? Зөв буруу, сайн муу хариулт гэж байхгүй тул та өөрийн мэдрэмжид тулгуурлан хариулт өгнө үү. Тийм / Үгүй гэсэн хариултын харгалзах нүдэнд ✓ тэмдэг тавина.

№	Асуулт	Тийм	Үгүй
1	Ямар нэгэн зүйлийг эргэн дурсахгүйн тулд тодорхой газар орон, хүмүүс болон үйл ажиллагаанаас зайлсхийдэг үү?		
2	Урд нь таатай, хөгжилтэй санагдаж байсан зүйл одоо сонирхолгүй санагдах болсон уу?		
3	Хүмүүсээс зай авч, хол баймаар санагдах болсон уу?		
4	Бусдад сэтгэл татагдах, хайрлах мэдрэмж багассан мэт санагдах болсон уу?		
5	Ирээдүйгээ төлөвлөх нь утгагүй санагдаж байна уу?		
6	Энэ явдлын дараа та өмнөх шигээ унтаж чадахгүй, эсвэл унтахад хэцүү байх болсон уу?		
7	Ердийн дуу чимээ, хэн нэгний хөдлөх чимээнээс амархан цочих болсон уу?		

4. CRIES асуулга

Заавар: Сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд дараах байдлууд хэр байгааг бодож хариулаарай.

	Сүүлийн 2 долоо хоногт	Үгүй	Ховор	Хааяа	Байнга
1	Тэр үйл явдлыг дурсаагүй байхад хар аяндаа санаанд орж ирээд байна уу?	0	1	3	5
2	Тэр үйл явдлыг ой санамжаасаа бүрмөсөн арилгамаар санагдаж байна уу?	0	1	3	5
3	Анхаарал төвлөрөхөд хэцүү болсон уу?	0	1	3	5
4	Тэр үеийн мэдрэмж үе үе хүчтэй орж ирдэг үү?	0	1	3	5
5	Үйл явдал болж өнгөрсний дараа илүү их амархан цочиж тавгүйтэх болсон уу?	0	1	3	5
6	Энэ тухай дурсахгүй байхыг хичээж байна уу?	0	1	3	5
7	Үйл явдлыг санагдуулах газар орон, нөхцөл байдлаас зайлсхийж байна уу?	0	1	3	5
8	Тэр талаар оюун санаандаа дүрслэн боддог уу?	0	1	3	5
9	Бусад юмс тэр талаар бодоход хүргэж байна уу?	0	1	3	5
10	Тэр талаар бодохгүй бахыг хичээж байна уу?	0	1	3	5
11	Амархан бухимдаж уцаарлах болсон уу?	0	1	3	5
12	Жирийн үед ч сэрэмжлээд байх болсон уу?	0	1	3	5
13	Нойр хямрах болсон уу?	0	1	3	5

Нийт оноо: _____

ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

	Эрх зүйн баримт бичгийн нэр	Огноо
1.	ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ	Монгол улсын хууль 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр
2.	ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ	Монгол улсын хууль 2016 оны 2 сарын 05 өдөр
3.	ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ	Монгол улсын хууль 2013 оны 7 сарын 05 өдөр
4.	“Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”, Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал”, “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал”,	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаал
5.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/148 дугаар тушаал
6.	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам	ЭМСайдын 2017-10-12-ны өдрийн А/394 дугаар тушаал
7.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам	УЕПрокурор, ХЗДХСайдын хамтарсан 2017-02-09-ны өдрийн А/22, А/31 тоот тушаал
8.	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам	ХЗДХСайдын 2017-01-31-ний өдрийн А/25 тоот тушаал
9.	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам	ХНХС, ХЗДХСайдын хамтарсан 2017-07-04-ний өдрийн А/1201, А/178 тоот тушаал
10.	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам	ХЗДХС, ЭМС, ХНХСайдын 2017-04-06-ны өдрийн А80, А/132, А/60/ тоот тушаал
11.	Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам	ХЗДХСайдын 2017-02-14-ний өдрийн А/38 тоот тушаал
12.	Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээний үнэлгээний маягт	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 сарын 20-ны өдрийн А/74 тоот тушаал
13.	Хамтарсан багийн ажиллах журам	ХНХСайдын 2016-12-26-ны өдрийн А/328 тоот тушаал
14.	Холбон зуучлах үйлчилгээний журам	ХНХСайдын 2017-04-20-ны өдрийн А/73 тоот тушаал
15.	Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам	ЭМСайдын 2017-10-12-ны өдрийн А/394 тоот тушаал
16.	Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам	ХЗДХС, ХНХСайдын 2017-3-13-ны өдрийн А/56, А/35 тоот тушаал
17.	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай	ЭМС-ын 2022 оны 03 сарын 18-ны өдрийн А/151 тоот тушаал

ХӨТӨЛБӨРИЙГ ДАГАЛДАХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

<i>Арга, техник</i>	<i>Хэрэглэгдэхүүн</i>	<i>Хөтөлбөрийн аль үед ашиглагдах</i>
Хамгаалах байран дахь нэгдсэн багц хэрэглэгдэхүүн		
Хөгжим заслын хэрэглэгдэхүүн	Спикер	НЭГ. Анхдагч холбоо тогтоох уулзалт ГУРАВ. Сэтгэл хөдлөл тогтворжуулхх уулзалт
	Memory card	
	Чихэвч	
Метафор картууд	Банхар карт Ий күү карт Шүхэр карт	НЭГ. Анхдагч холбоо тогтоох уулзалт ХОЁР. Сэтгэл зүйн үнэлгээ хийх уулзалт ГУРАВ. Сэтгэл хөдлөл тогтворжуулхх уулзалт
Булчингийн нөлөөллөөр тайвшруулах хэрэглэгдэхүүн	Иогийн гудас	Хөтөлбөрийн бүхий л хэсэгт үйлчлүүлэгчид нээлттэй байдлаар санал болгоно.
Өсвөр насны (11-16 нас) хүүхдэд зориулсан багц хэрэглэгдэхүүн		
Тайвшруулах зурах, будах хэрэглэгдэхүүн	Буддаг мандала ном	Хөтөлбөрт заасан арга техник үйлчлүүлэгчид тохиромжгүй байх тохиолдолд нээлттэй байдлаар санал болгоно.
	Тэмдэглэлийн дэвтэр	
	Нарийн фламастр	
Булчингийн нөлөөллөөр тайвшруулах хэрэглэгдэхүүн	Массажны хэрэгсэл	Хөтөлбөрийн бүхий л хэсэгт үйлчлүүлэгчид нээлттэй байдлаар санал болгоно.
	Базах, атгах бөмбөг	

НОМ ЗҮЙ

1. ЭМЯ, СЭМҮТ, Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ. УБ.,2020
<https://file.etuslamj.mn/public-picture/prevent/file/2.pdf>
2. Хүйсийн тэгш эрх ТББ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага. УБ.,2018
3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвтэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ. УБ.,2019
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт мониторингийн тайлан. УБ.,2018
5. ХНХЯ, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм - сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтын гарын авлага. УБ., 2019
6. ЦЕГ. “Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг”-ийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн хэсэгчилсэн судалгаа. 2019
<https://information.police.gov.mn/resource/information/File/2019/10/15/yxu1uiueel5okt82/%D0%A1%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0%20%D1%85%D2%AF%D2%AF%D1%85%D1%8D%D0%B41.pdf>
7. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮЧИНГИЙН ГЭМТ ХЭРЭГ.
http://www.upr-mongolia.mn/images/xupld/201910/Sexual_abuse_rape_UPR_mng.pdf
8. Хүүхдийг ивээх сан. Монгол улс дах хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ 2020.
https://www.savethechildren.mn/uploads/2021/05/CRSA_2020_book_final.pdf
9. ДЭМБ, бусад. INSPIRE ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН УДИРДАМЖ БОЛОН ҮР ДҮНГИЙН ХҮРЭЭ. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх: Өөрчлөлтийг хэрхэн тодорхойлж хэмжих вэ?
<https://www.unicef.org/mongolia/media/3061/file/INSPIRE:%20%D0%A8%D0%B0%D0%B-%D0%B3%D1%83%D1%83%D1%80%20%D2%AF%D0%B7%D2%AF%D2%AF%D0%BB%D1%8D%D0%B-%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%83%D0%B4%D0%B8%D1%80%D0%B4%D0%B0%D0%B-%D0%B6%20%D0%B1%D0%BE%D0%BB%D0%BE%D0%BD%20%D2%AF%D1%80%20%D0%B4%D2%AF%D0%BD%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD%20%D1%85%D2%AF%D1%80%D1%8D%D-1%8D.pdf>